



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот


“Удирдах зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн
бичгийн дарга нарыг сонгох, томилох тухай


Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.7 дахь заалт, БСШУС-ын Сайдын 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/202 дугаар тушаал, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийн 4.2, Удирдах зөвлөлийн дүрмийн 2.7, 2.8 дахь заалтууд, Удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлын тэмдэглэл, Удирдах зөвлөлийн гишүүдийн нээлттэй санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Үүсгэн байгуулагчийн санал болгосноор Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн даргаар Удирдах зөвлөлийн гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаярыг сонгосугай.

2. Үүсгэн байгуулагчийн санал болгосноор Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дэд даргаар Удирдах зөвлөлийн гишүүн, БШУЯ-ны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Г.Батнэмэхийг сонгосугай.

3. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ШУТИС-ийн Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Н.Ганзоригийг сонгосугай.

ДАРГА  ГАНБАЯР





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот


Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2020 оны төсвийн тодотгол батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11.3 дугаар заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.4 дүгээр заалт, Удирдах зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2020 оны үйл ажиллагааны орлогын төсвийг 58,020,325.400.0/тавин найман тэрбум хорин сая гурван зуун хорин таван мянга дөрвөн зуун/ төгрөгөөр тогтоож нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагааны зарлагын төсвийн тодотголыг 56,851,778.900.0 /тавин зургаан тэрбум найман зуун тавин нэгэн сая долоон зуун далан найман мянга есөн зуун/ төгрөгөөр тогтоож хоёрдугаар хавсралтаар, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг 3,482,900.0 /гурван тэрбум дөрвөн зуун нааян хоёр сая есөн зуун мянган/ төгрөгөөр тогтоож гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийн гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, батландсан төсвийн дагуу захиран зарцуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Захирал (Б.Очирбат)-д даалгасугай.

ДАРГА



Б.ОЧИРБАЯР